



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwuoцахимхаягэсх> лдээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	3-4
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	10
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	11
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	11
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	15
ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	16
ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА	17
4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд:	17
4.2. Экспорт:	20
4.3. Импорт:	24
ТАВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	27
5.1. Мөнгөний нийлүүлэлт:	27
5.2. Гадаад валютын албан нөөц:	29
5.3. Төлбөрийн тэнцэл:	30
ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	32
6.1. Хүн ам, ажил эрхлэлт:	32
6.2. Ажилгүйдэл:	32



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2024 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААН



Эдийн засаг 7.8 хувиар өсжээ. Эдийн засгийн өсөлт 2022 оны эхний улиралд -3.8 хувьтай байсан бол 2024 оны эхний улирлын байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 6.1 их наяд төгрөг болж, 7.8 хувьд хүрсэн байна. Энэхүү өсөлтөд уул уурхай, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, худалдаа, мэдээлэл холбооны салбарын өсөлт голлон нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 7,321.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 5,695.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,626.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 9.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 5.1 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 969.9 тэрбум төгрөгөөр өсөж, 1,626.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 7,321.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2,527.0 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 98.1 хувьтай байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 5,695.3 тэрбум төгрөгт хүрч, 69.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1,557.2 тэрбум төгрөгөөр буюу 37.6 хувиар нэмэгдсэн байна.

Засгийн газрын өр: Засгийн газрын өрийн хэмжээ 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 29,767.2 тэрбум төгрөг (нэрлэсэн дүн) байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3,641.9 тэрбум төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 6,073.1 сая ам.доллар, экспортын худалдаа 3,658.8 сая ам.доллар, импортын худалдаа 2,414.3 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 1,244.6 сая ам.долларын ашигтай гарсан. 2019-2024 оны эхний улирлын байдлаар экспорт дунджаар 26.5 хувиар, импорт 14.3 хувиар тус тус өссөн байна. Ялангуяа, 2021-2024 оны эхний улирлын байдлаар экспорт дунджаар 45.3 хувиар, импорт 20.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн оны мөн үетэй гүйцэтгэлтэй харьцуулахад 2024 оны эхний улирлын байдлаар экспорт 105.2 сая ам.доллар буюу 2.8 хувиар буурч, харин импорт 474.7 сая ам.доллар буюу 24.5 хувиар өссөн байна. Нийт экспортын орлогын 58.6 хувийг нүүрс, 17.3 хувийг зэсийн баяжмал, 4.9 хувийг алт, 2.9 хувийг төмрийн хүдэр, 2.4 хувийг боловсруулаагүй нефть, 1.8 хувийг жоншны баяжмал тус тус эзэлж байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 37,365.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 6,426.6 тэрбум төгрөг буюу 20.8 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 2,949.0 тэрбум төгрөг буюу 48.9 хувиар, төгрөгийн хадгаламж 5,009.5 тэрбум төгрөг буюу 38.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 7.0 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.2 нэгж хувиар буурсан байна. Инфляц 2023 оны 9 дүгээр сараас хойш 10-аас доош түвшин рүү орсон байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2024 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 596.5 сая ам.долларын алдагдалтай байсан хэдий ч хөрөнгийн тэнцэл 11.9 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 1,420.1 сая ам.долларын тус тус ашигтай гарсан. Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 294.1 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 79.6 сая ам.доллароор суларсан байна.

Гадаад валютын нөөц өслөө. Нийт албан нөөцийн хэмжээ 2024 оны 3 сард 5,249.8 сая ам.доллар болж, 2023 оны жилийн эцсээс 328.3 сая ам.доллар буюу 6.7 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 1,811.3 сая ам.доллар буюу 52.7 хувиар тус тус өссөн байна. Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2024 оны 3 дугаар сард 5,249.8 сая ам.доллар болж нийт импортын 6.5 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна.

Гадаад валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2023 оны 12 дугаар сард 3,378.0 төгрөг болж, өмнөх оноос 132.0 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 469.0 төгрөг болж, өмнөх оноос 45.0 төгрөгөөр мөн чангарсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл 1,259.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 124.3 тэрбум төгрөг буюу 9.0 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.3 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурлаа.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 2,058.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 167.4 тэрбум төгрөг буюу 7.5 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.1 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 2.5 нэгж хувиар буурчээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2024 оны эхний улирлын байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 6.1 их наяд төгрөг болж, 7.8 хувьд хүрсэн байна.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улиралд өсөж 1.9 хувьд хүрч байсан бол 2024 оны эхний улирлын байдлаар 7.8 хувийн өсөлттэй гарлаа.

График 1-д 2016-аас 2024 оны эхний улирлын байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ болон олон улсын зах зээлийн үнэ тус тус нэмэгдсэнээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, ялангуяа эдийн засгийн бодит өсөлт сайжрах төлөвтэй байна.

2024 оны эхний улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 16.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.4 хувь буюу 2.7 их наяд төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 6.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.8 хувь буюу 0.4 их наяд төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, мэдээлэл холбооны салбарын өсөлт голлон нөлөөлжээ.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад барилгын салбар 27.5 хувиар, мэдээлэл холбоо 21.3 хувиар тус тус өссөн бол хөдөө аж ахуйн салбар 26.9 хувиар буурчээ.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн хувь, салбараар /өмнөх оны мөн үетэй харьцуулахад/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл											
	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
ДНБ-ий бодит өсөлт	7.5	7.5	4.2	2.6	5.8	6.3	8.6	-10.1	14.8	-3.8	7.9	7.8
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	35.4	13.9	10.5	3.9	1.8	4.6	1.1	12.0	-4.5	11.3	-5.1	-31.4
Уул уурхай, олборлолт	6.8	19.8	13.4	13.7	-5.4	3.8	15.5	-32.9	38.5	-38.9	49.8	13.1
Боловсруулах үйлдвэрлэл	17.0	-12.2	12.0	-16.7	15.9	10.5	4.3	1.2	23.8	-10.1	-6.8	6.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6.5	3.4	5.4	3.4	3.0	9.1	2.7	5.5	6.8	6.1	4.0	7.7
Барилга	-5.4	23.0	29.1	43.0	-27.9	14.2	14.3	13.0	-0.4	-29.8	0.2	27.7
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	-15.0	-2.8	-10.5	-2.1	18.9	3.9	16.4	-13.6	6.1	8.5	9.3	6.5
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	13.4	9.8	0.6	-5.2	0.4	-2.3	10.2	-31.0	18.7	-31.9	76.3	27.2
Мэдээлэл, холбоо	20.0	5.3	-1.7	7.0	-8.6	1.5	15.8	5.2	13.7	14.7	5.0	26.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7.5	12.0	11.5	2.6	6.4	5.4	4.6	-3.0	0.8	4.3	1.2	3.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	24.7	-1.0	-15.7	-0.9	23.4	17.4	8.8	-8.1	46.4	9.8	-3.6	13.1


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт, оны үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эдийн засгийн өсөлт 2022 оны эхний улирлын байдлаар -3.8 хувьтай гарч байсан бол 2024 оны эхний улирлын байдлаар 7.8 хувь болж өссөн байна. Энэ нь 2019 оны мөн үе буюу ковидын өмнөх үеэс 17.9 нэгж хувиар өссөн үзүүлэлт боллоо.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2024 оны эхний улирлын байдлаар 16.9 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 20.0 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 6.6 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 7.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 2. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр

Үзүүлэлт	/тэрбум төгрөгөөр/							Өөрчлөлт (хувиар)
	2018-I	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I	2024-I	
ДНБ	6,516.3	7,665.2	7,133.6	9,084.9	9,700.8	14,044.1	16,853.1	20.0
Эцсийн хэрэглээ	5,417.5	6,166.3	6,975.7	6,316.1	7,768.3	8,783.9	12,367.0	40.8
Өрхийн хэрэглээ, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	4,505.3	5,075.4	5,707.6	5,194.0	6,425.3	7,096.8	8,959.7	26.2
Төрийн байгууллагын хэрэглээ	912.1	1,090.9	1,268.1	1,122.1	1,343.0	1,687.1	3,328.8	97.3
Хөрөнгийн нийт хуримтлал	1,841.7	1,980.9	2,003.6	2,491.0	3,409.3	3,461.9	4,178.1	20.7
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,379.6	1,949.8	1,768.6	2,028.6	2,364.5	3,100.5	3,019.8	-2.6
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	462.1	31.1	234.9	462.4	1,044.8	361.3	1,158.3	220.6
Цэвэр экспорт	-742.9	-482.0	-1,845.7	277.9	-1,476.9	1,798.3	308.0	-82.9
Бараа, үйлчилгээний экспорт	3,754.7	4,974.3	2,836.2	5,930.0	5,159.8	12,882.5	12,674.1	-1.6
Бараа, үйлчилгээний импорт	4,497.6	5,456.3	4,681.9	5,652.1	6,636.6	11,084.2	12,366.1	11.6


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр

Үзүүлэлт	/тэрбум төгрөгөөр/							Өөрчлөлт (хувиар)
	2018-I	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I	2024-I	
ДНБ	5,049.2	5,481.7	5,081.6	5,849.1	5,705.8	6,149.5	6,629.5	7.8
Эцсийн хэрэглээ	5,034.4	5,298.7	5,699.0	5,047.5	5,478.9	5,623.1	7,062.0	25.6
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	4,154.6	4,348.7	4,637.5	4,098.7	4,479.9	4,476.4	5,328.6	19.0
Төрийн байгууллагын хэрэглээ	879.8	950.0	1,061.5	948.8	999.0	1,146.6	1,686.4	47.1
Хөрөнгийн нийт хуримтлал	1,567.8	1,643.4	1,473.8	1,904.5	2,501.4	2,090.8	2,322.9	11.1
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,233.8	1,616.3	1,367.9	1,534.4	1,562.8	1,815.9	1,717.7	-5.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	334.0	27.1	105.9	370.1	938.7	274.9	605.1	120.1
Цэвэр экспорт	-1,553.0	-1,460.4	-2,091.3	-1,102.8	-2,274.5	-1,564.3	-2,755.3	76.1
Бараа, үйлчилгээний экспорт	2,888.2	2,993.4	1,716.9	3,123.0	2,207.3	5,196.6	4,734.6	-8.9
Бараа, үйлчилгээний импорт	4,441.2	4,453.8	3,808.2	4,225.9	4,481.8	6,760.9	7,489.9	10.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, их наяд төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад эдийн засгийн бодит өсөлт 7.8 хувиар /эцсийн ашиглалтын аргаар тооцсон/ өсөхөд өрхийн болон төрийн байгууллагын хэрэглээ өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 4. ДНБ-ий бодит өсөлт, салбараар, хувиар

Бүрэлдэхүүн	Эхний улирлын байдлаар							
	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
ДНБ	5.8	6.5	8.6	-7.3	15.1	-2.5	7.8	7.8
Эцсийн хэрэглээ	-1.0	19.5	5.2	7.6	-11.4	8.6	2.6	25.6
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус	1.8	4.3	11.7	5.8	2.1	-5.9	8.1	7.4
байгууллагын хэрэглээ	-0.2	22.9	4.7	6.6	-11.6	9.3	-0.1	19.0
Төрийн байгууллагын хэрэглээ	-4.2	5.4	8.0	11.7	-10.6	5.3	14.8	47.1
Хөрөнгийн нийт хуримтлал	330.2	85.5	4.8	-10.3	29.2	31.4	-16.4	11.1
Үндсэн хөрөнгийн хуримтлал	12.2	69.8	31.0	-15.4	12.2	1.9	16.2	-5.4
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	15.5	3.7	6.1	12.0	-5.3	-14.6	32.3	42.9
Цэвэр экспорт	17.5	11.5	32.7	8.6	-15.5	13.6	29.1	21.0
Бараа, үйлчилгээний экспорт	-126.3	182.0	-91.9	290.5	249.4	153.6	-70.7	120.1
Бараа, үйлчилгээний импорт	-1,421.0	386.9	-6.0	43.2	-47.3	106.3	-31.2	76.1
Бараа, үйлчилгээний экспорт	17.3	9.2	3.6	-42.6	81.9	-29.3	135.4	-8.9
Бараа, үйлчилгээний импорт	32.9	49.8	0.3	-14.5	11.0	6.1	50.9	10.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг хүнд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг ажилтанд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцоолоход 2024 оны эхний улирлын байдлаар 4.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар буюу 217.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Салбараар нь авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж 524.6 мянган төгрөг (4.4 хувь)-өөр нэмэгдсэн боловч үйлчилгээний салбарын бүтээмж 563.4 мянган төгрөг (11.6 хувь)-өөр, аж үйлдвэр, барилгын салбарын бүтээмж 376.1 мянган төгрөг (10.6 хувь)-өөр, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 15.8 мянган төгрөг (3.1 хувь)-өөр тус тус буурчээ.

Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

Бүрэлдэхүүн	Эхний улирлын байдлаар							/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт, 2024/2023	
	2018	2019	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	3,878.3	4,263.8	3,718.3	4,818.2	4,332.2	4,218.6	4,435.8	217.2	5.1
Хөдөө аж ахуй	683.4	698.1	886.6	719.6	809.5	510.3	494.5	-15.8	-3.1
Уул уурхай, олборлолт	15,260.0	15,292.5	11,803.8	18,136.9	9,707.8	11,964.8	12,489.4	524.6	4.4
Аж үйлдвэр, барилга	3,213.4	3,541.6	3,309.4	4,108.6	3,191.7	3,556.5	3,180.4	-376.1	-10.6
Үйлчилгээ	3,639.9	4,007.4	3,394.5	4,538.2	4,411.7	4,855.5	4,292.1	-563.4	-11.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 7,321.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 5,695.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,626.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 2,527.0 тэрбум төгрөг буюу 52.7 хувиар, төсвийн нийт зарлага 1,557.2 тэрбум төгрөг буюу 37.6 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	Өөрчлөлт(+/-)	
		2024.01/2023.01			(3-2)	(3-2)/2
	1	2	3	(3:1)	(3-2)	(3-2)/2
	2024.01	2023.01	2024.01	Гүйц/төл	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7,462.6	4,794.8	7,321.9	98.1	2,527.0	52.7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	8,224.1	4,138.2	5,695.3	69.3	1,557.2	37.6
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-761.5	656.6	1,626.5	-213.6	969.9	147.7
ДНБ, оны үнээр		13,781.6	16,453.6		2,672.0	
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		4.8	9.9		5.1	

Эх сурвалж: : Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 98.1 хувийн, нийт зарлага 69.3 хувийн гүйцэтгэлтэй гарч, нийт тэнцэл 1,626.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 9.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.1 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 969.9 тэрбум төгрөгөөр өсөж, 1,626.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,321.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 52.7 хувиар буюу 2,527.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 1.9 хувь буюу 140.7 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Тэнцвэржүүлсэн нийт орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл улсын төсөв 1.2 хувь буюу 63.7 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 4.9 хувь буюу 74.8 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 7.6 хувь буюу 103.0 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 13.9 хувь буюу 70.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 59.3 хувь буюу 1,961.7 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 90.1 хувь буюу 695.7 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сан 35.5 хувь буюу 329.9 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 15.3 хувь буюу 57.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2023 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр, төсвийн шатлалаар


/тэрбум төгрөгөөр/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
Нийт орлого ба тусламжийн дүн	5,689.8	5,621.8	1,542.5	1,467.7	1,360.9	1,257.9	504.3	434.1
Ирээдүйн өв сан	254.8	284.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	101.0	67.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	5,334.0	5,270.3	1,542.5	1,467.7	1,360.9	1,257.9	504.3	434.1
Татварын орлого	4,733.5	4,798.0	1,257.5	1,190.7	978.1	875.1	504.3	434.1
Татварын бус орлого	600.5	472.4	285.0	277.0	382.9	382.9	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 92.4 хувийг татварын орлого, 7.6 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 5. Татварын болон татварын бус орлого /хувиар/




2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр Тогтворжуулалтын санд 100.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 254.8 тэрбум төгрөг хуваарилахаар төлөвлөснөөс Тогтворжуулалтын санд 67.5 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 284.0 тэрбум төгрөг хуваарилсан байна. Ирээдүйн өв сангийн хөрөнгө 111.5 хувийн биелэлттэй буюу 29.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 33.2 хувиар буюу 33.5 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

Нэгдсэн төсвийн татварын орлого 6,908.9 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 97.9 хувийн биелэлттэй байгаа ба өмнөх оны мөн үеэс 52.3 хувь буюу 2,373.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлого: Татварын орлогын 37.0 хувийг орлогын албан татвар, 13.3 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.6 хувийг хөрөнгийн албан татвар, 18.6 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 4.1 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 5.1 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 20.2 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 6. Татварын орлого /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн яам


2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 97.9 хувь буюу 6,908.9 тэрбум төгрөгийн биелэлттэй байна. Үүнд нийгмийн даатгалын орлого 86.2 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 92.9 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 84.9 хувийн биелэлттэй гарсан нь нөлөөлжээ. Харин орлогын албан татвар 4.1 хувь (100.2 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар (147.8 тэрбум төгрөг), онцгой албан татвар 14.0 хувь (34.5 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 7.6 хувь (0.5 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 1.6 хувь (21.7 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 52.3 хувь буюу 2,373.7 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 78.7 хувь (1,126.3 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 10.4 хувь (87.0 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 74.1 хувь (46.4 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 30.9 хувь (303.8 тэрбум төгрөг), онцгой албан татвар 68.8 хувь (114.2 тэрбум төгрөг), тусгай зориулалтын орлого 41.3 хувь (1.9 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 12.1 хувь (37.9 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 88.5 хувь (656.3 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын бус орлого 413.0 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 153.4 тэрбум төгрөгөөр буюу 59.1 хувиар өссөн бол төлөвлөснөөс 9.4 тэрбум төгрөг буюу 2.3 хувиар давж биелжээ.

Татварын бус орлого: Татварын бус орлогын 82.1 хувийг нийтлэг татварын бус орлого, 17.7 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 33.9 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.4 хувийг газрын тосны орлого, 16.4 хувийг хүүгийн орлого, 12.8 хувийг бусад орлого, 16.4 хувийг хүүгийн орлого, 14.3 хувийг торгуулийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна.

График 7. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад гадаад хандив тусламжийн орлого 33.6 тэрбум төгрөгөөр, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.8 тэрбум төгрөгийн дутуу биелэлтэй байна.

Нийтлэг татварын бус орлогоос хүүгийн орлого 33.8 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 27.8 тэрбум төгрөг, торгуулийн орлого 10.7 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 10.8 тэрбум төгрөгөөр, бусад орлого 13.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн бол навигаацийн орлого 52.1 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 0.4 тэрбум төгрөгөөр, хувьцааны ногдол ашгийн орлого 0.3 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,224.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 69.3 хувийг зарладагж, 2,528.8 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,557.2 тэрбум төгрөг буюу 37.6 хувиар өсөж, 5,695.3 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн зарлага

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨО-ны мөн үеийн /2023.01/	2024 оны 1 дүгээр улирал			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,138.2	8,224.1	5,695.3	69.3	-2,528.8
НИЙТ ЗАРЛАГА	4,157.7	8,004.3	5,540.9	69.2	-2,463.3
УРСГАЛ ЗАРДАЛ	3,669.7	6,098.8	4,698.0	77.0	-1,400.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	938.5	2,580.4	1,768.1	68.5	-812.3
ХҮҮ	332.6	505.2	401.8	79.5	-103.4
ТАТААС	122.0	267.9	133.8	49.9	-134.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,276.6	2,745.3	2,394.3	87.2	-350.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	488.0	1,905.4	842.9	44.2	-1,062.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-19.5	219.9	154.4	70.2	-65.5

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 28.0 хувиар буюу 1,028.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 82.5 хувь буюу 4,698.0 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 51.0 хувийг урсгал шилжүүлэг, 37.6 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 8.6 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 2.8 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардал 829.6 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 117.7 тэрбум төгрөг, зээлийн үйлчилгээний төлбөр 69.2 тэрбум төгрөгөөр, татаас 11.7 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 354.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 52.7 хувь буюу 2,527.0 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага 37.6 хувь буюу 1,557.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, төсвийн зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 15.1 нэгж хувиар бага гарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл өмнөх оны мөн үеэс 969.9 тэрбум төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д “Засгийн газрын өр”-ийг тодорхойлсон, тухайлбал 4.1.8.а-д өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, 4.1.8.б-д хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг” гэж тодорхойлсон. Засгийн газрын дотоод өр гэж өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг, Засгийн газрын гадаад өр гэж Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг тус тус ойлгоно.

Хүснэгт 9. Засгийн газрын өр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар								
	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024*
I. Засгийн газрын дотоод өр	4,134.5	4,442.4	2,706.0	1,533.5	1,359.4	1,136.6	657.2	836.6	196.6
Үнэт цаас	3,345.1	4,438.3	2,706.0	1,533.5	1,359.4	1,136.6	657.2	836.6	196.6
II. Засгийн газрын гадаад өр	8,696.8	14,001.4	16,636.7	18,927.9	21,180.1	24,390.0	25,436.5	31,319.8	29,541.4
Үнэт цаас	3,406.8	6,821.7	7,288.2	7,631.4	8,050.1	8,354.4	8,450.5	10,592.3	8,703.3
Зээл	5,290.0	7,179.7	9,348.5	11,296.4	13,130.0	16,035.6	16,985.9	20,727.5	20,838.1
III. Засгийн газрын бусад өр	3,097.7	2,576.6	2,140.0	1,889.0	2,012.6	1,806.1	1,448.7	1,252.7	29.2
Засгийн газрын өрийн баталгаа	2,860.6	1,870.7	1,549.6	1,084.6	1,055.5	964.2	815.7	778.7	29.2
Барих-шилжүүлэх концесс	237.1	705.9	590.4	804.4	957.1	841.9	633.0	474.0	0
Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдэл (I+II+III)	15,929.0	21,020.4	21,482.7	22,350.4	24,552.1	27,332.7	27,542.4	33,409.1	29,767.2
Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ)	-	-	-	-	-	-	22815.3*	29,075.1*	26552.1*

Эх сурвалж: : Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Засгийн газрын өрийн хэмжээ 2024 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 29,767.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,641.9 тэрбум төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна. Үүнд; Засгийн газрын дотоод үнэт цаас 640.0 тэрбум төгрөгөөр буюу 76.5 хувиар, Засгийн газрын гадаад өр 1,778.4 тэрбум төгрөгөөр буюу 5.7 хувиар, Засгийн газрын бусад өр 1,223.5 тэрбум төгрөг буюу 97.7 хувиар, үүн дотроо Засгийн газрын өрийн баталгаа 749.5 тэрбум төгрөгөөр буюу 96.3 хувиар, барих-шилжүүлэх концесс 474.0 тэрбум төгрөгөөр буюу 100.0 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.


Засгийн газрын өрийн хэмжээг ковидын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад 7,416.8 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар өссөн байгаа ба үүнд Засгийн газрын гадаад өр 10,613.5 тэрбум төгрөгөөр буюу 56.1 хувиар өссөн (гадаад үнэт цаас 1,071.9 тэрбум төгрөг буюу 14.0 хувь, гадаад зээл 9,541.7 тэрбум төгрөг буюу 84.5 хувь) нь нөлөөлжээ.

ДӨРӨВ. ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2024 оны эхний улирлын байдлаар 160 гаруй улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 6,073.1 сая ам.долларт хүрсэн нь 2019 онтой харьцуулахад 3,015.6 сая ам.доллар буюу 98.6 хувиар, өнгөрсөн оноос 369.5 сая ам.доллар буюу 6.5 хувиар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ ковидын өмнөх түвшингээс давж, гадаад худалдааны тэнцэл сүүлийн 10 жил дараалан ашигтай гарлаа. Тухайлбал, гадаад худалдааны тэнцэл 2019 онд 486.1 сая ам.долларын ашигтай байсан бол 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 1,244.6 сая ам.долларт хүрч 2.5 дахин нэмэгдсэн байна.

График 8. Гадаад худалдааны үзүүлэлт, 2018.03-2024.03 оноор /тэрбум ам.доллар/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.1. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлтүүд

2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 6,073.1 сая ам.доллар, экспортын худалдаа 3,658.8 сая ам.доллар, импортын худалдаа 2,414.3 сая ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 1,244.6 сая ам.долларын ашигтай тус тус гарсан.

График 9. Экспорт, импортын өөрчлөлт /хувь/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2019-2024 оны эхний улирлын экспорт жилд дунджаар 17.4 хувиар, импорт 10.7 хувиар тус тус өссөн нь гадаад худалдааны нийт бараа эргэлт болон гадаад худалдааны ашиг нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Ялангуяа, 2021-2024 оны эхний улирлын экспорт жилд дунджаар 26.3 хувиар, импорт 20.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад 2023 онд экспорт 2,645.9 сая ам.доллар буюу 21.1 хувиар, импорт 548.1 сая ам.доллар буюу 6.3 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 10. Гадаад худалдааны үндсэн үзүүлэлт, 2020-2024 оны эхний улирлаар

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлт	2,193.11	3,524.1	3,632.7	5,703.6	6,073.1	369.5	6.5
Экспорт	1,036.4	2,000.4	1,942.0	3,764.0	3,658.8	-105.2	-2.8
Импорт	1,156.7	1,523.7	1,690.7	1,939.6	2,414.3	474.7	24.5
Тэнцэл	-120.4	476.7	251.4	1,824.4	1,244.6	-579.8	-31.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 579.8 сая ам.доллаароор буурч 1,244.6 сая ам.долларын ашигтай гарсан. Импортыг экспортоор нөхөх коэффициент 2023 оны эхний улирлын байдлаар 194.1 хувь байсан бол 2024 оны мөн үед 151.5 хувь болжээ.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 98.7 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 97.2 хувийг тус тус эзэлж байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 1,244.6 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 579.8 сая ам.доллар буюу 31.8 хувиар буурсан байна. Валютын төлбөртэй экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 129.9 сая ам.доллар буюу 3.5 хувиар буурч, харин валютын төлбөртэй импортын орлого 477.3 сая ам.доллар буюу 25.5 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл

/сая ам.доллаароор/


Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар				Харьцуулсан хувь (2024/2023)
	2021	2022	2023	2024	
НИЙТ БАРАА ЭРГЭЛТ	3,524.1	3,632.7	5,703.6	6,073.1	6.5
А.Экспорт	2,000.4	1,942.0	3,764.0	3,658.8	-2.8
А1.Валютын төлбөртэй бараа	1,972.5	1,910.7	3,740.0	3,610.1	-3.5
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	98.6	98.4	99.4	98.7	-0.7
В.Импорт	1,523.7	1,690.7	1,939.6	2,414.3	24.5
В1.Валютын төлбөртэй бараа	1,474.8	1,652.9	1,869.6	2,346.9	25.5
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	96.8	97.8	96.4	97.2	0.8
С. Тэнцэл (А-В):	476.7	251.4	1,824.4	1,244.6	-31.8
Д. Импортыг экспортоор нөхөх коэффициент ((А/В)*100)	131.3	114.9	194.1	151.5	-42.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2024.03)-аар тооцон үзэв.

2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

График 10. Гадаад худалдааны үзүүлэлтүүдийн өөрчлөлт



Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Монгол Улсын гадаад худалдаанд хөрш орнууд (ОХУ, БНХАУ) томоохон хувийг эзэлдэг. Тухайлбал, 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр хөрш орнууд нийлээд Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 80.7 хувь, экспортын 92.0 хувь, импортын 63.7 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс:

-БНХАУ-тай хийсэн худалдаа нь Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 69.0 хувь (4.2 тэрбум ам.доллар), экспортын 91.2 хувь (3.3 тэрбум ам.доллар), нийт импортын 35.5 хувь (856.9 сая ам.доллар)-ийг эзэлжээ.

-ОХУ-ын хувьд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 11.7 хувь (710.1 сая ам.доллар), экспортын 0.8 хувь (29.4 сая ам.доллар), нийт импортын 28.2 хувь (680.7 сая ам.доллар)-ийг эзэлж байна.

-2024 оны эхний улирлын байдлаар БНХАУ-тай хийсэн худалдаа 2,478.3 сая ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа 651.3 сая ам.долларын алдагдалтай байна.

Бусад улс оронтой хийсэн худалдаа гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 19.3 хувь, экспортын 8.0 хувь, импортын 36.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 12. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

Улс орон	Төрөл	Эзлэх хувь /2024.03/	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт (+/-)	
			2020	2021	2022	2023	2024	2024.03/2023.03	
								Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	69.0	1,236.9	2,440.8	2,048.2	4,217.4	4,192.1	-25.3	-0.6
	Экспорт	91.2	904.6	1,849.7	1,528.5	3,476.3	3,335.2	-141.1	-4.1
	Импорт	35.5	332.3	591.2	519.7	741.1	856.9	115.8	15.6
	Тэнцэл		572.3	1,258.5	1,008.9	2,735.2	2,478.3	-256.9	-9.4
ОХУ	Нийт эргэлт	11.7	400.6	437.4	583.3	539.4	710.1	170.7	31.6
	Экспорт	0.8	11.0	27.8	42.8	21.9	29.4	7.5	34.2
	Импорт	28.2	389.6	409.6	540.5	517.5	680.7	163.2	31.5
	Тэнцэл	-	-378.6	-381.8	-497.7	-495.6	-651.3	-155.7	31.4
Бусад	Нийт эргэлт	19.3	555.6	645.9	1,001.2	946.8	1,170.9	224.1	23.7
	Экспорт	8.0	120.8	123.0	370.7	265.8	294.2	28.4	10.7
	Импорт	36.3	434.8	522.9	630.5	681.0	876.7	195.7	28.7
	Тэнцэл	-	-314.0	-400.0	-259.9	-415.2	-582.5	-167.3	40.3


/сая ам.доллар/

4.2. Экспорт:

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр экспортын худалдаа 3,658.8 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 105.2 сая ам.доллар буюу 2.8 хувиар буурсан хэдий ч 2019 он (Цар тахлын өмнөх үе)-той харьцуулахад 1,887.0 сая ам.доллар буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 11. Экспорт, бүлгээр



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2019 онтой харьцуулахад 2020-2024 оны эхний улиралд эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт хоёулаа өссөн байна. 2019 онтой харьцуулахад 2022 онд эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт өсөж, харин эрдэс бүтээгдэхүүний экспорт буурсан байна.

2024 оны эхний улиралд эрдэс бүтээгдэхүүний экспорт 3,246.3 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 87.6 сая ам.доллар буюу 2.6 хувиар буурсан байна. 2024 оны эхний улиралд эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 88.7 хувь байна.

Хүснэгт 13. Экспорт, бүлгээр /2019.03-2024.03/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт экспорт	1,036.4	2,000.4	1,942.0	3,764.0	3,658.8	-105.2	-2.8
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний экспорт	886.0	1,776.1	1,530.9	3,333.8	3,246.3	-87.5	-2.6
Эрдэс бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь	85.5	88.8	78.8	88.6	88.7	-	0.1
2. Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	150.4	224.3	411.0	430.2	412.5	-17.7	-4.1

Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүнд нүүрс, зэсийн баяжмал, алт, төмрийн хүдэр, түүхий газрын тос, жоншны баяжмал, цайрын баяжмал зэрэг бүтээгдэхүүн хамаарч байна.

Нийт экспортын орлогын 58.6 хувийг нүүрс, 17.3 хувийг зэсийн баяжмал, 4.9 хувийг алт, 2.9 хувийг төмрийн хүдэр, 2.4 хувийг боловсруулаагүй нефть, 1.8 хувийг жоншны баяжмал тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмал, алт, цайрын баяжмалаас бусад эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого өссөн байна.

Хүснэгт 14. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Гол нэр төрлийн бараа	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нүүрс (сая.т)	3.1	6.8	2.5	14.2	18.1	3.9	27.5
Зэсийн баяжмал(мян.т)	306.6	316.3	334.8	362.9	367.4	4.5	1.2
Алт (тн)	1.6	0.4	4.8	2.6	3.1	0.5	19.2
Төмрийн хүдэр (сая.т)	2.1	1.9	0.6	1.3	1.8	0.5	38.5
Боловсруулаагүй нефть (сая.барр)	0.3	1.4	0.0	1.2	1.1	-0.1	-8.3
Жоншны баяжмал (мян.т)	137.1	194.1	50.9	175.9	267.7	91.8	52.2
Цайрын баяжмал (мян.т)	36.9	31.0	21.9	57.9	18.6	-39.3	-67.9
Молибдены баяжмал (мян.т)	1.5	1.6	1.1	1.8	1.6	-0.2	-11.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/


Гол нэр төрлийн бараа	Экспортод эзлэх хувь	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
		2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нүүрс	60.8	252.8	692.2	675.2	2272.3	2225.0	-47.3	-2.1
Зэсийн баяжмал	17.4	351.2	621.1	710.9	631.6	638.1	6.5	1.0
Алт	5.8	80.4	25.7	288.0	156.0	213.9	57.9	37.1
Төмрийн хүдэр	4.0	141.1	238.5	57.5	108.4	144.7	36.3	33.5
Боловсруулаагүй нефть	2.3	17.7	78.4	0.0	88.5	82.6	-5.9	-6.7
Жоншны баяжмал	1.6	35.3	42.6	11.5	44.0	58.2	14.2	32.3
Цайрын баяжмал	0.6	48.4	46.4	41.2	98.1	23.7	-74.4	-75.8
Молибдены баяжмал	0.6	11.2	11.9	15.2	38.3	22.9	-15.4	-40.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Зэсийн баяжмал: 2024 оны эхний улиралд 367.4 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, экспортын орлого 638.1 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 6.5 сая ам.доллар буюу 1.0 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 4.5 мянган тонн буюу 1.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.


График 12. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төмрийн хүдэр: 2024 оны эхний улирлын байдлаар 1.8 сая.тонн төмрийн хүдэр экспортолж, 144.7 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс төмрийн хүдрийн экспортын орлого 33.5 хувь буюу 36.3 сая ам.доллаароор өссөн. Үүнд төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 0.5 сая.тн-оор өссөн нь нөлөөлжээ. Экспортын дундаж үнэ 80.4 ам.доллар болж өнгөрсөн оноос 3.6 хувиар буурчээ.

График 13. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Алт: 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 3.1 тонн алт экспортолж, экспортын орлого 213.9 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар өссөн байна. Өнгөрсөн оны мөн үеэс алтны экспортын тоо хэмжээ 0.5 тонн буюу 19.2 хувиар, үнэ 15.0 хувиар тус тус өссөн нь алтны экспортын орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

Жоншны баяжмал: 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр жоншны баяжмалын экспортын тоо хэмжээ 267.7 мянган тонн-д хүрч, 58.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Жоншны баяжмалын биет хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 52.2 хувь буюу 91.8 мянган тонноор өссөн нь жоншны экспортын орлого өсөхөд голлон нөлөөлжээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад экспортын орлого буурсан эрдсийн бүтээгдэхүүнийг авч үзвэл:

Нүүрс: 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 18.1 сая тонн нүүрс экспортолж, 2.2 тэрбум ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад экспортын биет хэмжээ 3.9 сая тонн буюу 27.5 хувиар өссөн байна. Доорх графикаас харахад нүүрсний экспортын орлого нэмэгдэхэд нүүрсний экспортын тоо хэмжээ өссөн нь голлон нөлөөлжээ. 2024 оны эхний 3 сард дундажаар сард 6.0 сая тонн нүүрс экспортолж байсан нь өмнөх онуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

График 14. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Боловсруулаагүй нефть: 2024 оны эхний улирлын байдлаар 1.1 сая баррель боловсруулаагүй нефть экспортолж, 82.6 сая ам.долларын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад боловсруулаагүй нефтийн экспортын орлого 5.9 сая ам.доллар буюу 6.7 хувиар буурсан байна. Үүнд боловсруулаагүй нефтийн тоо хэмжээ 0.1 сая баррелиар буурсан нь голлон нөлөөлсөн.

Цайрын баяжмал: 2024 оны эхний улирлын байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 18.6 мянган тонн болж, 23.7 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын биет хэмжээ 18.6 мянган тонн болж, өнгөрсөн оны мөн үеэс 67.9 хувь буюу 39.3 мянган тонноор, мөн үнэ дундажаар 24.8 хувиар тус тус буурсан нь цайрын баяжмалын экспортын орлого 74.4 сая ам.доллар буюу 75.8 хувиар буурахад нөлөөлжээ.

Хөдөө аж ахуйн түүхий эдийн экспорт: 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 36.3 тонн угаасан ноолуур, 161.5 тонн самнасан ноолуур, 1.3 мянган тонн хонины самнаагүй ноос, 66.0 тонн богийн өлөн гэдэс зэрэг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг экспортолжээ. Ноолуур, хонины ноос, адууны мах болон богийн өлөн гэдэс экспортлон, нийт экспорт 28.0 сая ам.долларын орлого олжээ.

Хүснэгт 16. Зарим хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Төрөл	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Угаасан ноолуур	0.8	11.2	30.4	2.6	1.6	-1.0	-38.5
Самнасан ноолуур	4.0	2.8	12.1	7.7	15.7	8.0	103.9
Хонины самнаагүй ноос	1.6	2.9	0.2	4.9	1.5	-3.4	-69.4
Богийн өлөн гэдэс	2.2	3.8	3.5	0.5	1.8	1.3	260.0
Адууны мах	0.0	8.5	0.0	41.8	9.2	-32.6	-78.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 17. Зарим хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ


Төрөл	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Угаасан ноолуур, тн	17.9	355.1	668.3	47.3	36.3	-11.0	-23.3
Самнасан ноолуур, тн	45.0	50.9	102.7	73.9	161.5	87.6	118.5
Хонины самнаагүй ноос, мян.тн	1.6	2.9	0.1	4.5	1.3	-3.2	-71.1
Богийн өлөн гэдэс, тн	125.5	171.4	129.4	69.5	66.0	-3.5	-5.0
Адууны мах, мян.тн	0.0	4.1	0.0	11.9	2.6	-9.3	-78.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

4.3. Импорт:

2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр импортын худалдаа 2,414.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 24.5 хувь буюу 474.7 сая ам.доллараар өссөн байна.

График 15. Импорт, бүлгээр



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2024 оны эхний улирлын байдлаар нийт импортын 25.9 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 74.1 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 624.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 140.0 сая ам.доллар буюу 29.0 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 1,789.8 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 334.2 сая ам.доллар буюу 23.0 хувиар өсжээ.

Хүснэгт 18. Импорт, бүлгээр /2019-2023 он/он/

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2020	2021	2022	2023	2024	Дүн	Хувь
Нийт импорт	1,156.7	1,522.7	1,690.7	1,939.6	2,414.3	474.7	24.5
Үүнээс:							
1. Эрдэс бүтээгдэхүүний импорт	290.8	275.7	386.5	484.0	624.5	140.5	29.0
Эрдэс бүтээгдэхүүний нийт импортод эзлэх хувь	24.5	25.1	18.1	22.9	25.0	-	-
2. Эрдэсээс бусад бүтээгдэхүүний импорт	865.9	1,247.0	1,304.2	1,455.6	1,789.8	334.2	23.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр нийт импортын 30.1 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 37.5 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 9.2 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 23.1 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Хүснэгт 19. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


Бүтээгдэхүүн	1 дүгээр улирлын байдлаар						Өөрчлөлт (сая ам.дол.)
	2022		2023		2024		
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	2024.03/ 2023.03
Хэрэглээ	609.0	36.0	573.0	29.5	726.0	30.1	153.0
- Түргэн эдэлгээтэй	346.0	20.5	296.0	15.3	314.0	13.0	18.0
- Удаан эдэлгээтэй	263.0	15.6	277.0	14.3	412.0	17.1	135.0
Хөрөнгө оруулалт	542.0	32.1	752.0	38.8	905.0	37.5	153.0
- Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	296.0	17.5	521.0	26.9	636.0	26.3	115.0
- Барилгын материал	184.0	10.9	164.0	8.5	189.0	7.8	25.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	62.0	3.7	67.0	3.5	79.0	3.3	12.0
Аж үйлдвэрлэлийн орц	204.0	12.1	189.0	9.7	222.0	9.2	33.0
- Хүнсний орц	5.0	0.3	6.0	0.3	27.0	1.1	21.0
- Химийн бүтээгдэхүүн	41.0	2.4	33.0	1.7	43.0	1.8	10.0
- Цахилгаан эрчим хүч	46.0	2.7	49.0	2.5	47.0	1.9	-2.0
- Бусад АҮ-ийн орц	103.0	6.1	93.0	4.8	98.0	4.1	5.0
Нефтийн бүтээгдэхүүн	330.0	19.5	423.0	21.8	557.0	23.1	134.0
- Дизель	151.0	8.9	261.0	13.5	337.0	14.0	76.0
- АИ-92, 95	138.0	8.2	111.0	5.7	165.0	6.8	54.0
- А80 ба бусад	41.0	2.4	52.0	2.7	55.0	2.3	3.0
Бусад	5.0	0.3	3.0	0.2	4.0	0.2	1.0
Нийт дүн	1,690.7	100.0	1,939.6	100.0	2,414.3	100.0	474.7

Эх сурвалж: Монголбанк

2023 оны эхний улиралтай харьцуулахад 2024 оны мөн үед импортын худалдаа 474.7 сая ам.доллаароор нэмэгдэхэд хэрэглээ 153.0 сая ам.доллар, хөрөнгө оруулалт 153.0 сая, нефтийн бүтээгдэхүүн 134.0 сая ам.доллаароор тус тус өссөн нь нөлөөлжээ. Үүний дотор машин, механик тоног төхөөрөмж, эд анги 115.0 сая ам.доллар, дизель түлш 76.0 сая ам.доллар, барилгын материал 25.0 сая ам. доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 135.0 сая ам.доллаароор тус тус нэмэгдсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оны мөн үеэс 134.0 сая ам.доллаароор өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ буурсан хэдий ч тоо хэмжээ 25.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Дизель түлшний импорт 76.0 сая ам.доллаароор нэмэгджээ. 2024 оны эхний улирлын эцсээр нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 117.4 ам.дол/баррель болж, 2023 оны жилийн эцсээс 5.7 хувиар өссөн байна.

График 16. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТАВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ**5.1. Мөнгөний нийлүүлэлт:**

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 37,365.4 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 6,426.6 тэрбум төгрөг буюу 20.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд төгрөгийн харилцах 2,949.0 тэрбум төгрөг буюу 48.9 хувиар, төгрөгийн хадгаламж 5,009.5 тэрбум төгрөг буюу 38.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 20. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар			Өөрчлөлт (+/-)	
				2024.03/2023.03	
	2022	2023	2024	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	26,483.1	30,938.8	37,365.4	6,426.6	20.8
Мөнгө M1	5,723.5	6,792.2	9,801.1	3,008.9	44.3
Төгрөгийн харилцах	4,996.6	6,024.8	8,973.8	2,949.0	48.9
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	726.9	767.4	827.4	60.0	7.8
Бараг мөнгө	20,759.6	24,146.6	27,564.3	3,417.7	14.2
Төгрөгийн хадгаламж	13,701.7	13,090.5	18,100.0	5,009.5	38.3
Валютын хадгаламж	4,280.6	5,954.8	4,497.3	-1,457.5	-24.5
Валютын харилцах	2,777.4	5,101.2	4,967.0	-134.2	-2.6
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	994.0	1,036.5	1,091.4	54.9	5.3

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр 29.1 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.9 их наяд төгрөг буюу 25.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 21. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар			Өөрчлөлт (+/-)	
				2024.03/2023.03	
	2022	2023	2024	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	22,086.6	23,230.8	29,139.4	5,908.6	25.4
-Хэвийн зээл	18,992.8	19,621.7	25,821.9	6,200.2	31.6
-Хугацаа хэтэрсэн зээл	969.3	1,383.6	1,259.3	-124.3	-9.0
-Чанаргүй зээл	2,124.5	2,225.6	2,058.2	-167.4	-7.5
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	4.4	6.0	4.3	-	-
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	9.6	9.6	7.1	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 58.9 хувь нь иргэдийнх, 39.6 хувь нь хувийн хэвшлийн байгууллагынх эзэлж байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 25,821.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6,200.2 тэрбум төгрөг буюу 31.6 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 88.6 хувийг хэвийн зээл, 7.1 хувийг чанаргүй зээл, 4.3 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар хугацаа хэтэрсэн зээл 1,259.3 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 124.3 тэрбум төгрөг буюу 9.0 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.3 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурлаа.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2024 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар чанаргүй зээлийн хэмжээ 2,058.2 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 167.4 тэрбум төгрөг буюу 7.5 хувиар буурчээ. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.1 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь хэмжээ 2.5 нэгж хувиар буурчээ.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2024 оны 3 дугаар сарын байдлаар 188.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 558.9 сая ширхэг үнэт цаас арилжаалжээ. Өнгөрсөн оны мөн үеэс үнэт цаасны арилжааны гүйлгээ 113.9 тэрбум төгрөгөөр, арилжаалсан үнэт цаас 300.7 сая ширхгээр тус тус нэмэгдсэн байна. 2024 оны 3 дугаар сард хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны нийт үнэлгээний дүн 11.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.2 их наяд төгрөг буюу 80.3 хувиар өссөн байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2024 оны 3 дугаар сард 44,351.6 нэгж болж, өмнөх оны мөн үеэс 5,812.4 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 оны 03 дугаар сард 3,378.0 төгрөг болж, өмнөх оноос 132.0 төгрөгөөр чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 469.0 төгрөг болж, өмнөх оноос 45.0 төгрөгөөр мөн чангарсан байна.

График 17. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн хани, /2024.03 байдлаар/ /төгрөгөөр/




Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 3 дугаар сард улсын хэмжээнд 7.9 хувьтай гарч, өмнөх оны мөн үеэс 5.3 нэгж хувиар буурсан байна.

2020-2022 онд тээвэр логистикийн хүндрэл, нийлүүлэлтийн саатлаас үүдэлтэйгээр хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөн нь дэлхийн улс орнуудад инфляц өндөр байхад голлон нөлөөлсөн. Монгол Улсын хувьд мөн шалтгааны улмаас удаан хугацаанд буюу 25 сарын туршид инфляц 10-аас дээш хувьтай байснаа 2023 оны 9 дүгээр сараас хойш 10-аас доош түвшин рүү орсон байна.

График 18. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, сар бүрийн өөрчлөлт,




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

5.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2024 оны 3 сард 5,249.8 сая ам.доллар болж, 2023 оны жилийн эцсээс 328.3 сая ам.доллар буюу 6.7 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 1,811.3 сая ам.доллар буюу 52.7 хувиар тус тус өссөн байна.

График 19. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллаароор/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2024 оны 3 дугаар сард 5,249.8 сая ам.доллар болж нийт импортын 6.5 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гадаад валютын албан нөөц 1,811.3 сая ам.доллаароор өссөн нь нийт импортын хэрэгцээг хангах түвшнийг 1.2 сараар нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 22. Гадаад валютын албан нөөц ба импорт


№	Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар				
		2020	2021	2022	2023	2024
1	Нийт импорт	1,156.7	1,522.7	1,690.7	1,939.6	2,414.3
2	Гадаад валютын нийт нөөц	4,094.2	4,774.6	3,318.6	3,438.5	5,249.8
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	10.6	9.4	5.9	5.3	6.5

/сая ам.доллар/

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Худалдан авсан алт: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2024 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр 3.4 тонн болж, 2023 оны мөн үеэс 1.2 тонноор өссөн байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ эхний 3 сарын байдлаар 2.2-5.3 тонн байсан. Үүний дотор 2020 онд буюу Ковидын үед хамгийн өндөр худалдан авалтыг хийсэн байна.

График 20. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2013.03-2024.03 гүйцэтгэл /тонн/



Эх сурвалж: Монголбанк

5.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2024 оны эхний 3 сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 596.5 сая ам.долларын алдагдалтай байсан хэдий ч хөрөнгийн тэнцэл 11.9 сая ам.доллар, санхүүгийн тэнцэл 1,420.1 сая ам.долларын тус тус ашигтай гарсан.

Төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн тэнцлүүд ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 294.1 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 79.6 сая ам.доллаароор суларсан байна.

2024 оны эхний улирлын байдлаар урсгал тэнцэл алдагдалтай гарахад бараа, үйлчилгээний худалдааны тэнцэл 523.6 сая ам.доллар, мөн анхдагч орлого 111.7 сая ам.долларын алдагдалтай байсан нь голлон нөлөөлсөн. 2024 оны эхний улирлын байдлаар хөрөнгийн тэнцэл 11.9 сая ам.доллар, мөн санхүүгийн тэнцэл 1,420.1 сая ам.долларын ашигтай тус тус гарсан байна.


Хүснэгт 23. Төлбөрийн тэнцэл, 2022-2024 оны эхний улирлын гүйцэтгэл

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын байдлаар			Өөрчлөлт
	2022	2023	2024	Дүн
I. Урсгал Тэнцэл	-753.4	315.2	-281.3	-596.5
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-622.6	613.6	90.0	-523.6
В. Анхдагч орлого	-267.4	-434.4	-546.1	-111.7
С. Хоёрдогч орлого	136.6	136.0	174.8	38.8
II. Хөрөнгийн тэнцэл	21.8	21.7	33.6	11.9
III. Санхүүгийн тэнцэл	290.9	-500.5	919.6	1,420.1
IV. Алдаа болон орхигдуулга	-512.9	243.3	-298.7	-542.0
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-953.6	79.6	373.7	294.1

Эх сурвалж: Монголбанк

График 21. Төлбөрийн тэнцэл, 2009-2024 он



Эх сурвалж: Монголбанк

ЗУРГАА. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАЙДАЛ

6.1. Хүн ам, ажил эрхлэлт


2024 оны эхний улирлын гүйцэтгэлээр улсын хэмжээнд 14.1 мянган хүүхэд шинээр төрсөн байна. 2024 оны эхний 3 сарын байдлаар нийт ажиллах хүчний тоо 1,364.6 мянга болж, 2023 оны жилийн эцсээс 119.0 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүчнээс 1,293.6 мянган хүн нь ажилтай, 71.0 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Өнгөрсөн онтой харьцуулахад 2023 онд ажилтай иргэдийн тоо 38.6 мянгаар нэмэгдэж, ажилгүй хүмүүсийн тоо 15.8 мянгаар буурсан байна. Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 37.8 (3.0%) мянгаар өсөж, ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 5.6 (7.3%) мянгаар буурсан зэрэг үзүүлэлттэй байна.

2024 оны 1 дүгээр улиралд 59.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар өссөн байна. Хүйсээр авч үзэхэд, эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 66.9 хувь, эмэгтэйчүүдийнх 52.3 хувь байна. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 56.3 хувь байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 933.3 мянга байна.

6.2. Ажилгүйдлийн түвшин

2024 оны 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 5.2 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурсан байна. Энэ нь өмнөх оноос ажилгүй хүний тоо буурч, ажилтай иргэдийн тоо нэмэгдэн эдийн засаг идэвхжиж, ажил эрхлэлт нэмэгдсэнтэй холбоотой байна.

График 18. Ажилгүйдлийн түвшин, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС